



ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА Ш.РАДНААСЭД ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2017.12.20 № 01/9231  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тогтоолын төсөл хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн "Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчилэн батлах тухай" 55 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт өөрчлөлт оруулуулахаар тогтоолын төслийг үүгээр Танд хүргүүлж байна.

Тогтоолын төслийг хянан үзэж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж өгнө үү.

Хүндэтгэсэн,

ДАРГА,  
ТЭРГҮҮН КОМИССАР



Х.ЭНХЖАРГАЛ

018259

## ТАНИЛЦУУЛГА

*“Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн тухай*

Авлигын эсрэг хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 55 дугаар тогтоолоор тус газрын “Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог баталж, орон тооны дээд хязгаарыг тогтоосон.

Авлигатай тэмцэх газрын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, шинээр даган мөрдөж байгаа хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс батлагдсан төсөвт нь багтаан Авлигатай тэмцэх газрын орон тооны дээд хязгаарыг өөрчлөн тогтоолгохоор Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 55 дугаар тогтоолоор тогтоосон тус газрын орон тооны дээд хязгаарыг 172 болгон тогтоолд өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулан танилцуулж байна.

Байгууллагын орон тооны дээд хязгаарыг өөрчлөн баталснаар ямар нэгэн нэмэлт зардал, санхүүжилт шаардагдахгүй юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хуулиар Прокурорын байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйл /Улсын прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба/, 45 дугаар зүйл /Мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагч/-ийг тус тус хүчингүй болгосноор Прокурорын байгууллагын дэргэдэх Мөрдөн байцаах албаны төрийн тусгай албан хаагчийн үйлдсэн авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүргийг Авлигатай тэмцэх газарт харьяалуулж, “Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 22 дугаар тогтоолоор Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг орон тоо, төсөв, эзэмшиж байгаа үл хөдлөх болон бусад эд хөрөнгө, техник хэрэгслийн хамт Авлигатай тэмцэх газрын мэдэлд шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Тухайн үед 2014 оны төсвийн тодотголоор Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны 47 орон тоог шилжүүлсний дараа Авлигатай тэмцэх газрын орон тооны дээд хязгаар, бүтцийг Улсын Их Хурлын тогтоолоор шинэчлэн батлуулахаар төлөвлөж, зохих шийдвэр гарах хүртэлх хугацаанд шилжин ирэх 47 орон тоог тус газрын бүтцийн нэгжүүдэд түр хуваарилан баталж, зохион байгуулалтын түр арга хэмжээ авах зөвшөөрлийг Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболдод хүсч 2014 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 01/2168 дугаар албан бичгийг хүргүүлсэн байна.

Хүсэлтийг судлан үзээд 2014 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 1/1856 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн ба Улсын Их Хурлын дарга З.Энхболдоос Монгол Улсын 2014 оны төсвийн тодотгол хийх хүртэлх хугацаанд Авлигатай тэмцэх газарт шилжин ирсэн 47 орон тоог бүтцийн нэгжүүддээ түр хуваарилан баталж, хэвийн үйл ажиллагааг нь үргэлжлүүлэн явуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг дэмжиж, байгууллагынхаа хэвийн үйл ажиллагааг хангах төсвийн санхүүжилтийг тухай бүр нь тавьж зохицуулах, Авлигатай тэмцэх газрын орон тооны дээд

хязгаарыг хуульд заасны дагуу Улсын Их Хурлаас шинэчлэн батлах тогтоолын төслийг боловсруулж өргөн мэдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг мэдэгдсэн болно.

“Эдийн засгийн идэвхижлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2014 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 34 дүгээр тогтоолын хавсралтын 1.1, “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 147 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас төсвийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, чиг үүргийн давхардлыг арилгах, шинээр орон тоо нэмэхгүйгээр төрийн албан хаагчдын орон тоог бууруулах, сул орон тоонд томилгоо хийхгүй байх талаар бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгосонтой холбогдуулан Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны 47 орон тооноос 20 орон тоог хэмнэж бууруулан, 27 албан хаагчийн орон тоог хүлээн авч, байгууллагын бүтцийн орон тоог 172 байхаар шинэчлэн тогтоон ажиллаж ирсэн байна.

Ийнхүү тогтоосон орон тоог Улсын Их Хурлын тогтоолоор одоог хүртэл албан ёсоор баталгаажуулаагүй байгаа тул тогтоолд өөрлөлт оруулахаар төслийг боловсруулсан болно.

---000---

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2017 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

**Тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Авлигын эсрэг хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2012 оны “Авлигатай тэмцэх газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 55 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн “145” гэснийг “172” гэж өөрчилсүгэй.

2.Энэ тогтоолыг 2017 оны 12 дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг